

## “АНД-ЭНЕРГИ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 2 сарын 19 өдөр

Дугаар 24/01

Орхон аймаг

### Ногдол ашиг хуваарилах тухай

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1, 46.2, 46.5 дахь заалтууд, 76 дугаар зүйлийн 76.1.12 дахь заалт, 2024 оны 2 дугаар сарын 19-ний өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн Анд-Энерги ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс **ТОГТООХ нь:**

1. “Анд-Энерги” ХК-ийн нийт хувьцаа эзэмшигчдийн нэгж хувьцаанд 90 мөнгө буюу нийт 70,263,682.2 төгрөг (далан сая хоёр зуун жаран гурван мянга зургаан зуун наян хоёр төгрөг хорин мөнгө)-ний ногдол ашгийг Компанийн хувьцаа эзэмшигчдэд мөнгөн хэлбэрээр хуваарилсугай.
2. Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах өдрийг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бүртгэлийн өдрөөр тасалбар болгон тогтоосугай.
3. Энэхүү тогтоолын 1 дэх хэсэгт заасан ногдол ашгаас хувь хүний болон хуулийн этгээдийн хувьд аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг суутган тооцож, “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-аар дамжуулан Хувьцаа эзэмшигчдийн дансанд байршуулах замаар ногдол ашиг олгох сүүлийн өдрийг 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрөөр тогтсугай.
4. Энэхүү тогтоолыг Улаанбаатар үнэт цаасны биржийн цахим хуудсаар дамжуулан хувьцаа эзэмшигчдэд хүргэхийг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга /Б.Тогос-Эрдэнэ/-д даалгасугай.
5. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Аудитын хороо /Д.Мөнхбат/-д үүрэг болгосугай.

ТУЗ-ИЙН ДАРГА



Т.БАРС

## “АНД-ЭНЕРГИ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 2 сарын 19 өдөр

Дугаар 24/02

Орхон аймаг

### Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны зардлын төсөв батлах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалт, “Анд-Энерги” ХК-ийн дүрмийн 11.9.3 дахь заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журмын 2.6.8 дахь заалт болон 2024 оны 2 дугаар сарын 19-ны өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн Анд-Энерги ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс **ТОГТООХ нь:**

1. “Анд-Энерги” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны зардлын төсвийг 89,998,320 (наян есөн сая есөн зуун ерэн найман мянга гурван зуун хорь)-н төгрөгөөр, зардлын төсвийн задаргааг хавсралтаар тус тус баталсугай.
2. Уг батлагдсан төсвийн дагуу зардлуудыг олгохыг Гүйцэтгэх захирал /Ц.Гүррагчаа/-д үүрэг болгосугай.

ТУЗ-ИЙН ДАРГА



Г.БАРС

**“Анд-Энерги” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2024 оны зардлын төсөв**



№	Зардлын нэр	А. Цалингийн зардал				Тайлбар
		Сар/улирал	Нэг сарын цалингийн зардал (₮)	Хүний тоо	Нэг жилийн цалингийн зардал (₮)	
1	ТУЗ-ийн даргын цалин	12	2,500,000	1	30,000,000	ТУЗ-ийн гишүүдийн цалин улиралд 660.000 төгрөг байх ба 140.000 төгрөгийг хурлын ирц, идэвх, оролцоо, хороодын ажилласан байдлаас шалтгаалан олгоно.
2	Байгууллагаас төлж буй НДШ				4,350,000	
3	ТУЗ-ийн нарийн бичгийн даргын цалин	12	1,200,000	1	14,400,000	
4	Байгууллагаас төлж буй НДШ				2,088,000	
5	ТУЗ-ийн гишүүдийн урамшуулал	1	552,000	8	4,416,000	
6	Байгууллагаас төлж буй НДШ				640,320	
7	ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшуулал	3	800,000	8	19,200,000	
8	Байгууллагаас төлж буй НДШ				2,784,000	
<b>Дүн</b>					<b>77,878,320</b>	
	Зардлын нэр	Б. Үйл ажиллагааны зардал				Тайлбар
		Тоо хэмжээ	Нэгж зардал (₮)	Давтамж	Нийт дүн (₮)	
9	Томилолтын зардал /Дотоод/	1	2,200,000	1	2,200,000	ТУЗ-ийн үйл ажиллагаатай холбоотой замын зардал, зочид буудал төлбөр /Зардлын баримтыг компанийн нэр дээр авсан байх ба уг тохиолдолд баримтыг үндэслэн томилолтын зардал олгоно /
10	Томилолтын зардал /Гадаад/	1	5,000,000	1	5,000,000	
11	Харилцаа холбооны зардал	1	10,000	12	120,000	ТУЗ-ийн дарга
12		1	10,000	12	120,000	ТУЗ-ийн нарийн бичиг
13	Бичиг хэргийн зардал	1	60,000	4	240,000	Бичиг хэргийн материал, шуудан холбоо
14	ТУЗ-ийн хурал зохион байгуулах зардал /Ээлжит болон ээлжит бус/	1	150,000	4	600,000	Цай, кофе бусад материал
15	Унааны зардал	1	30,000	12	360,000	ТУЗ-ийн үйл ажиллагаатай холбоотой ажил хөөцөлдөх, хүнтэй уулзах
16		1	20,000	4	80,000	Хурлын тэмдэглэлд гарын үсэг зуруулах, ТУЗ-ийн үйл ажил холбоотой ажил
17	Сургалтын зардал	1	500,000	2	1,000,000	ТУЗ-д шаарплагатай сургалтыг танимаар болон онланаар авах
18	Бусад зардал	1	200,000	12	2,400,000	Төлөөлөнд тусгагдаагүй гэнэтийн зардал
<b>Дүн</b>					<b>12,120,000</b>	
<b>Нийт зардал</b>					<b>89,998,320</b>	

Зардлын төсөв гаргасан:



Б.Тогос-Эрдэнэ

Хянасан:

Т.Барс

## “АНД-ЭНЕРГИ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 2 сарын 19 өдөр

Дугаар 24/03

Орхон аймаг

### Журам батлах тухай

“Анд-Энерги” ХК-ийн дүрмийн 11.9.2 дахь заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журмын 2.6.19 дахь заалт болон 2024 оны 2 дугаар сарын 19-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн Анд-Энерги ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс **ТОГТООХ нь:**

1. Хувьцаа эзэмшигчдийн хурал зохион байгуулах ажиллагааны журмыг Хавсралт 1, Дотоод хяналтын журмыг Хавсралт 2, Компанийн ёс зүйн дүрмийг Хавсралт 3, Мэдээллийн ил тод байдал, тайлагналын журмыг Хавсралт 4, ТУЗ-ийн нарийн бичгийн даргын үйл ажиллагааны журмыг Хавсралт 5, Ногдол ашиг хуваарилах журмыг Хавсралт 6-аар тус тус шинэчлэн баталсугай.
2. Дээрх журам шинэчлэгдэн батлагдаж байгаатай холбогдуулан өмнөх журмуудыг хүчингүй болгосугай.
3. Уг журмуудыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг ТУЗ-ийн гишүүд, Гүйцэтгэх захирал /Ц.Гүррагчаа/-д үүрэг болгосугай.
4. Журмын хэрэгжилтийг ханган, хяналт тавьж ажиллахыг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга /Б.Тогос-Эрдэнэ/-д үүрэг болгосугай.

ТУЗ-ИЙН ДАРГА



Т.БАРС



**АНД-ЭНЕРГИ ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ХУРЛЫН ШИЙДВЭР**

**(Хувьцааны код: AND)**

“Анд-Энерги” ХК-ийн ТУЗ-ийн ээлжит хурал 2024 оны 2 дугаар сарын 19-ны өдрийн 12<sup>00</sup> цагт онлайнгаар хуралдаж дараах шийдвэрийг гаргав. Үүнд:

1. “Анд-Энерги” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 2 дугаар сарын 19-ний өдрийн №24/02 тоот тогтоолоор нийт хувьцаа эзэмшигчдийн нэгж хувьцаанд 90 мөнгө буюу нийт 70,263,682.2 төгрөг (далан сая хоёр зуун жаран гурван мянга зургаан зуун наян хоёр төгрөг хорин мөнгө)-ний ногдол ашгийг компанийн хувьцаа эзэмшигчдэд мөнгөн хэлбэрээр тараахаар шийдвэрлэлээ.
2. “Анд-Энерги” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны зардлын төсвийг 89,998,320 (наян есөн сая есөн зуун ерэн найман мянга гурван зуун хорь)-н төгрөгөөр, зардлын төсвийн задаргааг хавсралтаар тус тус баталсугай.
3. Хувьцаа эзэмшигчдийн хурал зохион байгуулах ажиллагааны журмыг Хавсралт 1, Дотоод хяналтын журмыг Хавсралт 2, Компанийн ёс зүйн дүрмийг Хавсралт 3, Мэдээллийн ил тод байдал, тайлагналын журмыг Хавсралт 4, ТУЗ-ийн нарийн бичгийн даргын үйл ажиллагааны журмыг Хавсралт 5, Ногдол ашиг хуваарилах журмыг Хавсралт 6-аар тус тус шинэчлэн батлав.

**АНД-ЭНЕРГИ ХК**  
2024 оны 2 сарын 19-ний өдөр,  
Орхон аймаг